

ЭЗБШӨЧ төслийн сар тутмын цуврал

2007 оны 7, 8 дугаар сар

Нээлттэй Засаг вэбсайт үндэсний олон нийтийн мэдээллийн хэрэгслээр "Торгоны зам бүдгэрч байна уу?" шууд ярилцлага зохион байгууллаа

Нээлттэй засаг вэбсайтаас 8-р сарын 29-ний өдөр үндэсний телевиз, радиогоор дамжуулан олон нийтийн шууд ярилцлага дахин зохион байгууллаа. Иргэд сонирхсон асуултаа суурин утас болон гар утасны богино мессежээр ирүүлсэн ба нэвтрүүлгийн явцад хүлээн авсан нийт 254 асуултын агуулга, төрлөөс үзвэл "Монголын Торгоны зам бүдгэрч байна уу?" гэсэн нэртэй энэхүү арга хэмжээ нь үзэгч, сонсогчдын сэтгэлд нийцсэн, цаг үеэ олсон сэдэв байв. Үүний зэрэгцээ ярилцлага нь Хятадын төмөр зам нь Монголд саатаад байгаа контейнерүүдийг буцааж ирүүлэх асуудлыг шийдвэрлэх



хүртэл Монгол руу явах, дамжин өнгөрөх ачааг тээвэрлэхийг 10 хоногээр түр зогсоосон үед зохион байгуулагдсанаараа онцлог байлаа.

Ярилцлагад доорх албан тушаалтнууд оролцов. Үүнд:

- Монгол Улсын Гаалийн ерөнхий газрын дарга Б. Баттөмөр
- Монголын Төмөр замын хэрэг эрхлэх газрын дарга Да. Ганболд
- "Улаанбаатар Төмөр Зам" Хувь нийлүүлсэн нийгэмлэгийн дарга Б. Отгондэмбэрэл
- Монголын Үндэсний Худалдаа, аж үйлдвэрийн танхимын дарга С. Дэмбэрэл нар оролцож үзэгч сонсогчдын сонирхсон асуултаудад хариулт өгсөн.

Ярилцлага зохион байгуулах тухай өдөр тутмын сонин, үндэсний телевизээр урьдчилан зарласна ба ярилцлагын үеэр ирүүлсэн асуултаудаас үзэхэд хамгийн их анхаарал татсан асуудал нь төмөр замын нөхцөл байдлыг сонирхсон асуултауд байсан ба эдгээр нь нийт асуултын 69 орчим хувийг

(174) эзэлж байсан бол гаальтай холбоотой асуулт 15 хувь, "Транзит Монгол" хөтөлбөрийн талаархи асуулт 6 хувийг тус тус эзэлж байлаа. Харин 10 хувь нь сэдвээс гадуурхи асуулт байсан.



НЭЭЛТТЭЙ ЗАСАГ

ТОРГОНЫ ЗАМ БҮДГЭРЧ БАЙНА УУ
шууд ярилцлагад урьж байна

Гаалийн ерөнхий газрын дарга Б. Баттөмөр,
Төмөр замын хэрэг эрхлэх газрын дарга Да. Ганболд,
Үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхимын дарга, Худалдаа,
тээврийн хөгжмэлх үндэсний хорооны оролцогч дарга С. Дэмбэрэл,
"Улаанбаатар Төмөр Зам" Хувь нийлүүлсэн нийгэмлэгийн дарга
Б. Отгондэмбэрэл
нар оролцоно.

Ярилцлага 2007 оны
VIII сарын 29-ний
Алага гарагийн
21:10 цагаас

Монголын Үндэсний телевиз
Монголын Үндэсний Радио
FM 106 радиогоор
шууд явагдах болно.

Утас SMS

Таны оролцох боломж:

НЭЭЛТТЭЙ ЗАСАГ ВЭБ ХУУДАС
www.open-government.mn

Ярилцлагын үеэр оролцогчид төмөр замын дэд бүтэц, машин тоног төхөөрөмжийг шинэчлэн сайжруулах хангалттай хөрөнгө оруулалт хийгээгүйгээс системийн хэмжээнд нөхцөл байдал улам бүр хүндэрснийг хүлээн зөвшөөрч, Засгийн газраас төмөр замын тогтолцоонд хувийн хөрөнгө оруулалтыг зөвшөөрөх чиглэлд тодорхой арга хэмжээ авч байгааг танилцуулсан.

Шинээр батлагдсан "Төмөр замын тээврийн тухай" хуулиар төмөр замд хувийн хөрөнгө оруулалтыг зөвшөөрч байгаа ба төмөр замын суурь дэд бүтэц нь төрийн мэдэлд байхаар зохицуулжээ. Төмөр замын хэрэг эрхлэх газрын дарга Да. Ганболд төмөр замын тогтолцоог боловсруулж болгох чиглэлд дотоод, гадаадын хөрөнгө оруулалтыг зохицуулах тухай журам удахгүй гарах гэж байгааг онцлов. Тэрбээр мөн төмөр замын үйлчилгээний одоогийн нөхцөл байдлыг сайжруулахын тулд Мянгану Сорилын Корпорациас авах буцалтгүй тусламжийн хүрээнд зүтгүүр, хөдлөх бүрэлдэхүүний паркийг шинэчлэхээр хэлэлцэж байгаагаа дурьдсан юм.

Энэхүү нийтлэлд илэрхийлсэн санал бодол нь АНУ-ын Олон улсын хөгжлийн агентлаг болон АНУ-ын Засгийн газрын санал бодлыг заавал тусгасан байх албагүй болно.

Түүнчлэн шууд ярилцлага нь "Транзит Монгол" хөтөлбөрийн талаар олон нийттэй ярилцах боломж олголоо. Энэхүү хөтөлбөр нь улсынхаа өрсөлдөх чадвар, давуу талууд дээр суурилан Монгол Улсыг БНХАУ, ОХУ, цаашилбал Ази Европыг холбосон худалдаа тээврийн дамжин өнгөрөх гарц болгох бодлогыг дэвшүүлжээ. Засгийн Газрын Худалдаа тээврийн хөнгөвчлөх Үндэсний хорооны удирдлага ЭЗБШӨЧ төслийн техникийн туслалцаатайгаар энэхүү хөтөлбөрийг боловсруулж байна.

Энэхүү шууд ярилцлагын явцад олон нийтэд төмөр замын тээвэртэй холбоотой асуудлууд, түүний үйл ажиллагааг сайжруулахад их хэмжээний хөрөнгө оруулалт шаардагдаж байгааг тайлбарлан ойлгуулсны зэрэгцээ Монгол Улс нь Хятад, Европыг холбосон өрсөлдөх чадвар бүхий худалдаа тээврийн гарц болсноор эрэлт, хэрэгцээгээ хангахын зэрэгцээ, цаашид орлогоо нэмэгдүүлэх боломж байгааг товч таниуллаа. Ярилцлагад оролцогчид транзит тээвэр, ложистикийн салбарыг хөгжүүлэх нь Монгол Улсын хөгжилд асар их ач холбогдолтой болохыг онцлов. Мөн Монгол Улс нь "Торгоны зам"-ын чухал бүрэлдэхүүн хэсэг байх сууриа хадгалах асуудалд онцгой анхаарал хандуулж тодорхой арга хэмжээ авахын чухлыг дурдаад – энэ удаад транзит тээврийг маш



эрчимтэй хөгжүүлэхын тулд Монгол улсаар дамжих коридорыг илүү хямд, түргэн шуурхай, аюулгүй, үр ашгитай болгоход анхаарлаа хандуулах шаардлагатайг онцлон дурдсан.

Санхүүгийн зохицуулах хороо, Монголын Ипотекийн Корпораци Үнэт цаасжилтын тухай хуулийн төслийн талаархи амралтын өдрийн уулзалтыг ивээн тэтгэлээ.

Барьцаат мөргөжлийн бондын болон Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн төсөл боловсруулах Ажлын хэсгийн уулзалт 8-р сарын 6-12-ны өдрүүдэд Жаргалант амралтын төвд болж, уулзалтыг Санхүүгийн зохицуулах хороо (СЗХ), Монголын Ипотекийн корпораци (МИК) хамтран ивээн тэтгэлээ.

Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд дараахь гишүүд орсон юм. Үүнд:

- СЗХ-ны Зөвлөлийн гишүүн, Ажлын хэсгийн ахлагч СЗХ-ны ажилтан х. Дүгэржав
- СЗХ-ны Үнэт цаасны газрын дарга н. Ганбат
- СЗХ-ны эдийн засагч н. Түмэнбаяр
- СЗХ-ны мэргэжилтэн х. Мөнхцалмаг
- Хууль зүй, дотоод хэргийн яамны хуульч н. Майзориг
- Сангийн яамны мэргэжилтэн х. Халиун
- Барилга, хот байгуулалтын яамны зөвлөх х. Бүтэд

- Барилга, хот байгуулалтын яамны мэргэжилтэн н. Хаш-Эрдэнэ
- УИХ-ын Тамгын газрын ажилтан х. Цэрэндулам
- Орон сууцны санхүүжилтийн корпорацийн ажилтан н. Мөнх-Алдар

Амралтын өдрийн энэхүү уулзалтын үеэр дээрх хуулиудын төслийг эцэслэхэд Ажлын хэсгийн гишүүд шаргуу ажиллаж, 8-р сарын 9-ний өдөр хүрсэн үр дүнгийнхээ талаар танилцуулсан юм.

Ажлын хэсгийн ахлагч х. Дүгэржав СЗХ-ны дарга н. Баярсайхан, Барилга, хот байгуулалтын яамны (БХБЯ) Төрийн нарийн бичгийн дарга н. Ганхүү, Хууль зүй, дотоод хэргийн яамны (ХЗДХЯ) Төрийн нарийн бичгийн дарга н. Баясгалан, Орон сууцны санхүүжилтийн корпорацийн (ОССК) дэд захирал н. Мөнхжаргал, МИК, ЭЗБШӨЧ төслийн ажилтнуудад үнэт цаасжилтын тухай шинэ хуулиуд болон тэдгээрийн онцлогийн талаар товч танилцуулга хийв.

Дугуй ширээний ярилцлага презентациар үргэлжилсэн бөгөөд оролцогчид хуулийн ач холбогдлыг онцолж, эдгээрийг УИХ-д өргөн барих, ирэх чуулганаар батлуулахын төлөө хамтран ажиллахаар тохиролцлоо. Түүнчлэн оролцогчид Ажлын хэсгийн дараачийн алхам болох дээрх хуулиудын төслийг Засгийн газарт хэлэлцүүлэхээр өргөн барихын өмнө Хууль зүй, дотоод хэргийн яамаар удирдуулсан албан ёсны өргөжүүлсэн Ажлын хэсэгт эдгээрийн монгол хэлнээ боловсруулсан эцсийн хувилбарыг өргөн барьж, бүх яамд болон бусад оролцогчдод хүргүүлж санал авахаар тохиролцов.

Ажлын хэсгээс үнэт цаасны анхдагч болон хоёрдогч зах зээлийн асуудлуудад техникийн шинжтэй хүндрэл гарч байгаа, түүнчлэн зах зээлийн үйл ажиллагаа нь харьцангуй шинэ учраас олон нийтийн боловсролыг дээшлүүлэх хүчтэй кампанит ажил зохион байгуулахыг санал болгож, дараахь тэргүүлэх чиглэлийг тодорхойллоо. Үүнд:

Мөртгэжлийн нэр томъёо, түүний процессийн цагаан толгой эсхүл жижиг гарын авлага

Монгол улсын хувьд хуулийн нэр томъёо, ойлголт тодорхойлолтууд, механизм нь шинэ, тогтсон нэр томъёо, хэллэг байхгүй байгаа учраас хуулийн төсөл боловсруулагчдаас эдгээрийг нийцүүлэх нь чухал ач холбогдолтой болохыг онцолсон юм. ЭЗБШӨЧ төсөл нь энэ санаачлагыг дэмжихээр боллоо.

Үндэсний мэдээллийн хэрэгслээр шууд ярилцлага зохион байгуулах

Нээлттэй Засаг вэбсайт нь төслийн техникийн туслалцааны дэмжлэгтэйгээр үндэсний телевиз, радио ашиглан үзэгч, сонсогчдоос оролцогчдод шууд асуулт тавьж болох шууд ярилцлага амжилттай зохион байгуулж ирлээ. Ярилцлагад оролцогчдоос Нээлттэй Засаг вэбсайтын ивээлд Засгийн Газрын Хэрэг эрхлэх газраас МИК, ЭЗБШӨЧ төсөл, банкуудтай хамтран шууд ярилцлага үргэлжлүүлэн хийхийг санал болгосон.

Сонингийн нийтлэл

МИК нь бусад талуудтай хамтран мөртгэж, түүний зах зээл, үнэт цаасжилтын үндсэн ойлголт, түүний ажиллагааг тайлбарласан нийтлэлийг сонингийн тогтмол нүүрэнд нийтэлж болох юм.

Түүнчлэн ЭЗБШӨЧ төсөлд барьцаат бонд эсхүл хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасаар дамжуулан хоёрдогч зах зээлийн үйл ажиллагаанд оролцох арилжааны банкуудын эрх зүйн хүрээг бүрдүүлэх зорилготой дээрх хоёр хуулийн талаар банкны салбарынханд презентаци тавих, ярилцлага зохион байгуулахад МИК, Монголбанк (МБ), Монголын Банкны холбоонд (МБХ) туслалцаа үзүүлэхийг санал болгож байсан юм.



Аялал жуулчлалын санал болгох бүтээгдэхүүнийг бий болгох: Цаа бугын малчид Цаатанд туслалцаа үзүүллээ

ЭЗБШӨЧ төсөл нь Итгэл сангийн хүсэлтээр цаатан малчдад орлогын эх үүсвэрийг олшруулахын тулд орон нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлалыг хөгжүүлэх, менежмент хийхэд туслалцаа үзүүлэх хамтарсан санхүүжилттэй төсөл хэрэгжүүлж байна. Хамтарсан санхүүжилттэй төслийн үйл ажиллагааны хүрээнд Монголын Өрсөлдөх Чадвар Сангийн (МӨЧС) багахан хэмжээний буцалтгүй тусламжаар Цагааннуур суманд аялал жуулчлалын чадавхийг хөгжүүлэх, аялал жуулчлалаас олсон орлогыг зохистой удирдахад дэмжлэг үзүүлэх зорилгоор орон нутгийн сургалт семинар зохион байгууллаа.

Монгол улс нь онгон байгальд илүү ойр байх, туршлага хуримтлуулахыг хүсч буй аялагчдын сонирхлыг ихээр татаж буй аяллын зорих газар болж байгаа учраас аялагчдын хүсч буй байгалийн онгон төрхийг хадгалах, хөдөөгийн хүн ард үр өгөөжийг илүү шууд байдлаар хүртэж чадах, ирээдүйд аялал жуулчлалыг тогтвортой хөгжүүлэх санал болгох бүтээгдэхүүнийг бий болгох, хөгжүүлэх хэрэгцээ улам бүр нэмэгдэж байна. Хөвсгөл нуурын орчмоор аялж, ер бусын "цаа бугын хүмүүс"-ийг харах зорилгоор ирсэн мянга мянган хүмүүсийг оролцуулахгүйгээр тооцвол цаатнуудыг зорьж ирсэн аялагчдын тоо 2002 онд 20 орчим байсан бол 2006 онд бараг 200-д хүрчээ.

Хөвсгөлийн хойд хэсэгт амьдардаг цаа бугын малчид гэгдэх цаатнууд нь Монгол улсын хамгийн алслагдмал газарт байрлах хамгийн цөөн ястан үндэстний нэг бөгөөд үндэсний нэн ядуу хэсэгт багтдаг юм. Улаанбаатар хотоос 1000 км орчим зайд, Цагааннуур сумын нэлээд хэсэгт нь дамнан байрлах Саяны нуруун дахь алслагдсан тайгын экосистемд 42 цаатан өрх амьдарч байна. Цаатнууд нь зүүн, баруун тайга гэсэн хоёр газарт суурьшин амьдарч байна. 42 өрхийн дүнгээр авч үзвэл тэдний 38% нь ядуу, 33% туйлын ядуу хүн амд ангилагдаж байна.

Одоогийн байдлаар цаатан өрхийн жилийн дундаж орлого 100 ам.доллар байгаа нь бүсийн хэмжээнд тогтоосон ядуурлын түвшингээс буюу нэг хүнд ногдох сарын 37,000 төгрөгнөөс доогуур байгаа юм. Эдийн засгийн боломж бололцоо хомс, эрүүл мэндийн болон хүн амын бусад үйлчилгээг хүртэх боломж хязгаарлагдмал, улмаар цаа бугын тоо толгойн өөрчлөлт тогтворгүй байгаа нь цаатан ардыг цаашид оршин тогтноход аюул учруулж байна. Мөнгөн орлого, эдийн засгийн боломж бололцооны цөөн тооны эх үүсвэр нь цаа бугын аж

ахуйн үйл ажиллагааг унагаах, шилжих хөдөлгөөний хэв шинжийг өөрчлөхөд, улмаар уламжлалт соёл гээгдэхэд хүргэж байна. Тайга, түүний ойр орчмоос олж буй орлогын эх үүсвэрт самар, жимс түүж борлуулах, гар урлал, агнасан зэрлэг амьтны гаралтай бүтээгдэхүүн зарж борлуулах, Дархад хүмүүст хөлсөөр өвс хадах ажил багтаж байна. Эдгээр нь бүгд улирлын чанартай, урьдаас таамаглах боломжгүй ажил төдийгүй тэднийг амьжиргаагаа дээшлүүлж ядуурлын шугамаас арай дээгүүр амьдрахад нь төдийлөн дэм болж чадахгүй байна.

ЭЗБШӨЧ төслийн хамтарсан санхүүжилтээр Итгэл сан, сайн дурынхан, төрийн бус байгууллагууд Цаатан иргэдийн болон Аялагчдын төвийг дэмжих зорилго бүхий төслийн нэг, хоёрдахь шатны үйл ажиллагааг дуусгаад байна. Орон нутгийн тогтвортой байдлыг хангахын тулд төслийн хэрэгжилтийн хугацаанд орон нутгийн удирдлага, менежментийн ур чадварыг хөгжүүлэх, сайн дурын үйл ажиллагаа, мэргэжлийн зөвлөх үйлчилгээг дэмжих чиглэлд курс сургалт зохион байгууллаа. АНУОУХА/ЭЗБШӨЧ төслийн туслалцааны хүрээнд курс сургалтын хөтөлбөрийг боловсруулахад техникийн туслалцаа үзүүлэх, зохион байгуулалт, үйл ажиллагааны чиглэлд зөвлөгөө өгөх, сайн дурын ажилтнуудын томилолтын болон дотоодын аяллын зардлыг санхүүжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зэрэг багтсан юм.

Цаатангууд Итгэл сангийн дэмжлэгтэйгээр мэдээлэл, тээвэрлэлтийн хангамж бүхий цаатан ардын уламжлалыг тайлбарласан төвтэй, мөн гар урлалын зүйлийн дэлгүүр бүхий Аялагчдын төвийн хоёр давхар барилгыг барьж дуусгаад байна. Төвийн залгаа урц барьж тоноглогсон. Зүүн, баруун тайгт адил тооны цаатан өрхүүдийг хамруулсан 4-6 өдрийн сургалтын үеэр олж авсан мэдлэгийг практикт баталгаажуулахын тулд 10 гаруй жуулчдыг урьж, хөтчөөр ажиллуулсан юм. Эдгээр нь Итгэл сангийн түнш дөрвөн тур операторын шугамаар ирсэн жуулчид байлаа. Төслийн зохион байгуулагчид, зөвлөх түншүүдэд цаатнуудын уйгагүй хичээл зүтгэл, итгэл, урам зоригийг олж харахад таатай байсан юм: 6-р сарын сүүлийн долоо хоногт болсон Хөдөөгийн оролцооны үнэлгээний сургалт семинарт оролцсон цаатан өрхийн 85% нь өөрсдийн олсон орлогынхоо 40 хувийг үйлчилгээ үзүүлэгчийнхээ ажиллагаанд зарцуулахаар үлдээж, 60%-ийг нь нийтийн сандаа үлдээхээр шийдсэн ер бусын шийдвэр гаргасан байлаа.

ЭЗБШӨЧ төслийн аялал жуулчлалын салбар дахь хүчин чармайлт нь Монгол улсыг аялал жуулчлалын зорих газар болгох чиглэлээр олон улсад сурталчлах ажиллагааг дэмжихэд оршиж байна. Аялагчид нэгэнт Монгол улсад ирсэн бол орон нутгийн хосгүй, ер бусын уламжлалыг хадгалсан аялал жуулчлалын зохистой бүтээгдэхүүнээр үйлчлүүлэх, тухайлбал Итгэл сангийн удирдлагаар хэрэгжсэн Цаатан төслийн хүрээнд бий болгосонтой адил тэдэнд таатай байх, ер бусын онцгой сэтгэгдэл, туршлага үлдээсэн аялал жуулчлалын бүтээгдэхүүн бий болгох шаардлагатай байна.

Энэхүү цуврал нь ЭЗБШӨЧ төслийн үйл ажиллагааны тухайн сар тутмын цахим хэвлэл юм. Та өөрийн санал бодол, манай цувралыг захилах буюу захиалгаа цуцлах хүсэлтийг ЭЗБШӨЧ төслийн цувралын эрхлэгчид дараахь хаягаар ирүүлнэ үү. И-мэйл fbertoli@eprc-chemonics.biz, факс: (976-11) 32 78 25.